

# Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны III улирлын тойм мэдээ

# СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД БОЛОН ТЭМҮҮЛЛҮҮД

## ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА

- Эрүүл, аюулгүй орчин, оролцоо ба олон талт байдлыг дэмжсэн ажлын байр, соёлыг бүрдүүлнэ
- Үе үеийн төлөөлөл бахархалтайгаар мөр зэрэгцэн ажиллах орчин нөхцөл бүрдүүлж, ур чадвартай ажилтнуудыг татаж, тогтвортой ажиллах урам зоригоор сэлбэнэ
- Дэлхийн түвшинд өндрөөр үнэлэгдэх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ

## БАЙГАЛЬ ОРЧНОО ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн зорилтын хүрээнд компанийн түвшинд хүлэмжийн хийг аль болох бууруулах арга замуудыг эрэлхийлнэ
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан, сайжруулна
- Компанийн үйл ажиллагаанаас газар, ус, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах илүү оновчтой арга замыг тодорхойлно
- Улс орны хэмжээнд усны хангамж, нөөц, чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана
- Уурхайн хаалтын дараах нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахад бизнесийн үйл ажиллагааг чиглүүлнэ



## ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

- Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлэн төлөвшүүлнэ
- Оролцогч талуудтайгаа харилцан ашигтай зорилгын дор нэгдэнэ
- Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл явцыг хурдасгах зорилгоор бизнесийн түншүүдтэйгээ хамтран ажиллана
- Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллана

## ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

- Урт хугацаанд үр ашгаа хүртээх, дэлхийд тэргүүлэх зэсийн үйлдвэрлэлийг цогцлооно
- Стратегийн төлөвлөгөөгөө оновчтой болгож, хүдрийн биетийн судалгаанд хөрөнгө оруулснаар үр ашгийг хамгийн боломжит дээд түвшинд хүргэж нэмэгдүүлнэ
- Нэгдмэл, уян хатан, шинийг санаачлагч байж, шинэ техник, технологи ашиглан, тасралтгүй суралцаж хөгждөг шилдэг компани байна
- Эрчим хүчний хангамж зэрэг ханган нийлүүлэлтийн сүлжээний чадамж, тогтвортой байдлыг сайжруулах, мөн дээд зэрэглэлийн бүтээгдэхүүнийг харилцагчдын хүрээг өргөжүүлэн нийлүүлнэ

# Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон

ШИЛДЭГ АЖИЛ  
ОЛГОГЧ БАЙНА




Хамтын  
ажиллагаа



Хөрст дэлхий



Хүртэх өгөөж



## АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ МЭНД

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд зогсоох эрхтэй.

2023 ОНЫ ГУРАВДУГААР  
УЛИРЛЫН БАЙДЛААР

**26,663,820** ХҮН/ЦАГ

2023 оны эхний гурван улиралд гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.19 ногдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.



## ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАВТАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

\*0.23-ААС БАГА БАЙЛГАХ

ГҮЙЦЭТГЭЛ **0.19**



## БОЛОВСРОЛ СУРГАЛТ (НИЙТ ХҮН/ЦАГ)

Нийт 622,818 хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ур чадварыг нь өсгөсөөр байна.



ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН,  
МАЛЧИН ӨРХИЙН ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ  
2010 оноос хойш Өмнөговийн **517** оюутан



БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР  
(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)  
2010 оноос хойш **3,916** оюутан



ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН  
ХӨТӨЛБӨР  
2013 оноос хойш ахлах ангийн **1,592** сурагч



ХАМТ ОЛОН

**97.2%**

ҮҮРЭГ 90%

Нийт ажиллах хүчний 97.21 хувийг монгол иргэн бүрдүүлж байна. Харин 34.76 хувь нь гүний уурхайн төслийн ажилтнууд юм.



ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

**23.4%**

2023 ОНЫ ЗОРИЛТ 25%

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia

# Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын ажиллагаа

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА



Хөрст дэлхий



Хүртэх өгөөж



## ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД



68%



ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

32%



ХАНБОГДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ОЮУ ТОЛГОЙН ХУРДАСГУУР САН

Тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 2023 оны эхний гуравдугаар улирлын байдлаар 26.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Эрүүл мэнд, сайн сайхан байдал	9%
Боловсрол	39%
Байгаль орчин	6%
Орон нутгийн бизнесийн хөгжил	0.9%
Түүх, соёл	2%
Дэд бүтэц	43%
Спорт	0.1%

## ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010 - 2023, III УЛИРАЛ)

9.9

2010 ОНООС ХОЙШ ӨССӨН ДҮНГЭЭР

## ИХ НАЯД ТӨГРӨГИЙГ

### ТАТВАР ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨРТ ТӨЛЖЭЭ.

Татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ\* зэрэг бусад төлбөрт 9.9 их наяд төгрөг\*\* 2010 оноос хойш төлсөн. 2023 оны эхний гурван улиралд татвар, хураамж бусад төлбөрт 1 их наяд төгрөг төлжээ.

\* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

\*\* Энэ дүнд олон улсын арбитра хэлэлцэгдэж буй 1 их наяд төгрөгийн татварын маргааны төлбөр багтсан болно.

## ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ



75%

Аж ахуй нэгж, бусад байгууллагад төлсөн төлбөр (НӨАТ-тай)

19%

Улсын төсөвт төлсөн шууд төлбөрүүд

6%

Цалин

Үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, бусад хамтын ажиллагаа, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 2010 оноос хойш 38.8 их наяд төгрөг зарцуулаа.

## ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ

(2010 - 2023, III УЛИРАЛ)

26.9

ӨССӨН ДҮНГЭЭР

## ИХ НАЯД ТӨГРӨГ

2023 оны эхний гурван улиралд үйл ажиллагааны худалдан авалтын баг 812 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 704 нь дотоодын ханган нийлүүлэгчид байв. Эдгээр дотоодын компанид худалдан авалтынхаа 88 хувийг зарцуулав. 2010 оноос хойш дотоодын худалдан авалтад 26.9 их наяд төгрөг зарцуулсан.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ

(2010 - 2023, III УЛИРАЛ)

3.8

ИХ НАЯД ТӨГРӨГ

2023 оны эхний гурван улиралд Өмнөговь аймагт бүртгэлтэй 113 ханган нийлүүлэгчээс 719.9 тэрбум төгрөгийн бараа, үйлчилгээ авлаа. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт 3.8 их наяд төгрөгийн бараа, үйлчилгээ авчээ.

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia

# Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын ажиллагаа



Хөрст дэлхий

БАЙГАЛЬ ОРЧНОО  
ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА



Хүртэх өгөөж



## УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013 - 2023, III УЛИРАЛ)

# 161

ТЭРБУМ ТӨГРӨГ



2023 оны гуравдугаар улирлын байдлаар ус ашигласны төлбөрт 161 тэрбум төгрөг төлсөн.

# 86.7%

2023 оны гуравдугаар улирлын байдлаар ус дахин ашиглалтын түвшинг дунджаар 86.7 хувьд хүргэв.



## “100 САЯ МОД” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Жилд Ханбогд суманд 250,000, Цогт-Овоо суманд 500,000 тарьц, суулгац ургуулах хүчин чадалтай хоёр мод үржүүлгийн газрыг байгуулсан.

Богд уулын Түргэний аманд түймэрт өртсөн 20 га талбайд ойжуулалтын ажил хийсэн.


Сэлэнгэ аймгийн Ялбагийн хөндий дэх, хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр хөндөгдөж, орхигдсон 400 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Нийт 55,000 мод, тарьц, суулгацыг 2600 ажилтанд тараасан.

Ханбогд сумын 35 га талбайд 30,000 мод тарьсан.

## УСНЫ ХЭРЭГЛЭЭ


(НЭГ ТОНН ХҮДЭР БОЛОВСРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН УСНЫ ХЭМЖЭЭ, ШОО МЕТР, САРААР)



Нэг тонн хүдэр боловсруулахдаа нөхөн сэлбэлтээр 0.39м3 буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

## ЛАНДФИЛЛД БУЛСАН ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

(ХУВЬ, САРААР)



2023 оны гуравдугаар улирлын байдлаар нийт үүссэн хаягдлын 68 хувийг дахин боловсруулсан байна.

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia

# Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын ажиллагаа



Хөрст дэлхий




Хүртэх өгөөж

ТОГТВОРТОЙ  
ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ



## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(МЯН.ТОНН)



Бид 2023 оны гуравдугаар улиралд зорилтоо давж, нийт 127,419 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв.

## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ


(МЯН.УНЦ)



Бид 2023 оны гуравдугаар улиралд зорилтоо давж, нийт 135,646 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв.

## ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(МЕТР, САРААР)



Бид 2023 оны гуравдугаар улиралд гүний уурхайд хөндлөн малталтын гүйцэтгэлийн хувьд 12,208 метрийн ахицтай байв.

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны III улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia